Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анх дугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А.Д.Х.Гүйцэтгэх захиргааны сонин.

17 дэх жилдээ №92 (1397) | 1964 оны 12 дугаар сарын 10 | ПҮРЭВ

### ШАРХАЙН ХӨДИЙД

Алтанбулаг сумын МХЗЭ—ийн үүрийн дарга Доржоор удирдуулсан МХЗЭ—ийн гишүүд залуучууд сүрэл татах үүрэг авч ажиллаад 6 хоногт 1200 п,есс хийж төлийн пүнз барих ажлыг одооноос эхлэн бэлдэж байна, Энд нийт найман залуучууд ажиллаж байгаагийн дотроос энгийн залуу Оргоо,Сирий нар нь хүч чармайн ажиллаж бусдыгаа хушуучлан явж байна. Мөн эдгээр ажилласаг залуус өглөө оройн цаг ашиглаж 100 гүү саах хашаа нэгийг барьж, Шархайн хөндийд хөдөлмөр оргилуулж байна.

*Раднаа*

### ЦАСНЫ БАЯР

Саяхны нэг амралтын өдөр Баянчандманий сургуулийн сурагчид „цасны баяр" хийж биеийн тамирын өвлийн ажлаа нээлээ. Энэ баяраар 5—7 дугаар ангийн эрэгтэй сурагчдын 5 км, эмэгтэй сурагчдын 3 км—ийн уралдаан явагдаж сурагч Цэндсүрэн, Жамъяндорж нар тэргүүн байруудыг эзлэв. Бага насны эрэгтэй эмэгтэй хүүхдийн цаныг тэмцээнд Отгон,Жаргал нар түрүүллээ. Энэ „цасны баяр" шинэ цас орсны нөгөөдөр нь буюу 11 дүгээр сарын 22 нд болсон юм.

*Э.Дашдондог*

## АЙМГИЙН АДХ—ЫН 6 ДАХЬ УДААГИЙН 6 ДУГААР ЧУУЛГАНЫ СОНСГОЛ МЭДЭЭ

Аймгийн АДХ-ын 6 дахь удаагийн 6 дугаар чуулган 1964 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Зуунмодод болж «АДХ-ын Гүйцэтгэх захиргааны тайлан» аймгийн АДХ—ын Гүйцэтгэх захиргааны дарга, 8 дугаар тойргийн депутат Ц.Жамсран, «Аймгийн АДХ—ын дэргэдэх социалист хууль ёс нийгмийн хэв журмын байнгын комиссын тайлан» байнгын комиссын дарга, 7 дугаар тойргийн депутат Г.Балд—Осор, «Соёл гэгээрлийн байнгын комиссын тайлан» Байнгын комиссын дарга, депутат Х.Билгээ нарын илтгэлийг хэлэлцэв. Чуулганд аймгийн депутатуудаас гадна аймгийн намын хорооны бүгд хурлын гишүүд, сум—нэгдэл,сангийн аж ахуйн намын үүр хороодын нарийн бичгийн дарга нар, сум—нэгдэл, сум—сангийн аж ахуйн машинт станцын дарга нар болон албан үйлдвэрийн газрын дарга нар оролцов. Чуулганд хэлэлцсэн асуудлын талаар 16 хүн үг хэлж, дэлгэрэнгүй тогтоол гаргав. Тус чуулган аймгийн хэмжээгээр 1965-1966 онд явуулах соёлжилтын 2 жилийн зохистой ажлын ерөнхий төлөвлөгөөг батлав. Аймгийн АДХ—ын 6 дахь удаагийн 6 дугаар чуулган зарим газар хэлтэс албан байгууллагын дарга,орлогч нар өөр ажилд шилжсэнтэй холбогдуулж АДХ—ын Гүйцэтгэх захиргааны гэгээрлийн хэлтсийн даргаар Т.Гаваа,шүүхийн орлогч даргаар Бадарч,Эрүүлийг хамгаалах газрын даргаар Б.Галсандорж нарыг батлав.

## Аймгийн АДХ—ын 6 дахь удаагийн 6 дугаар чуулганд Аймгийн АДХ—ын гүйцэтгэх захиргааны ажлын тухай

### Аймгийн АДХ—ын гүйцэтгэх захиргааны дарга, депутат Ц.Жамсрангийн тавьсан ИЛТГЭЛЭЭС

ДЕПУТАТ НӨХӨД ӨӨ!

Манай орны яруу алдарт ард түмэн, энхрий хайрт нам засгаа нам нягтаар хүрээлж, МАХН—ын 14 дүгээр их хурлын дайчин шийдвэр, улс ардын аж ахуй,соёлыг хөгжүүлэх 3 дугаар таван жилийн төлөвлөгөөг амьдралд биелүүлэх тэмцэлдээ шинэ шинэ амжилтууд олсоор байна. 1963 онд улсын хэмжээгээр бүх малын тоо 1962 онд байснаас 1,4 саяар нэмэгдэж, 20 сая пүү үр тариа хураан авч, үйлдвэр соёлын бүх салбаруудад сайхан амжилт олов.

1964 онд 6,6 сая төл бойжуулж, 1963 оныхоос 10 гаруй хувиар үр тариа илүү хурааж авчээ.

Өнгөрсөн 1963 онд тус аймаг мал өсгөх улсын төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн хамт хөдөө аж ахуй,барилга угсралт,үйлдвэр улсын бэлтгэлийн төлөвлөгөөг амжилттай биелүүлж улсын гэргүүний аймгийн зэрэгт хүрлээ. Энэхүү амжилтандаа сэтгэл зориг нь бадарсан манай аймгийн хөдөлмөрчид 1964 оны улсын бэлтгэл, хадлан, тариа зэрэг төлөвлөгөөт зорилтуудыг амжилттай биелүүлж, түүнийгээ нам засагтаа баяр бахдалтай илтгээд байна.

Аймгийн АДХ—ын Гүйцэтгэх захиргаа засаг төрийн байгууллагаас аж ахуй соёлын ажлыг удирдах удирдлага,түүнд тавих хяналтыг сайжруулах төлөвлөгөөг үзүүлэлг бүрээр биелүүлэх, байгууллагуудын ажлыг дээр доор гүй жигд урагшлуулахад зохион байгуулалтын удирдлагын ажлаа чиглүүлж ирлээ.

Аймгийн АДХ—ын Гүйцэтгэх захиргаа социалист уралдааныг ажлын салбар бүхэнд өрнүүлэх асуудлыг удирдах ажлынхаа гол арга болгон хэрэглэж, байгуулсан уралдаан,авсан амлалтыг хэрэгжүүлэн түүний биелэлтийг 7,10 хоног, улирал хагас бүтэн жилээр дүгнэж, тэргүүний туршлагыг нийтийн хүртээл болгож сайчуудыг алдаршуулах,туршлагы нь солилцуулах, уулзалт зөвлөлгөөн зохиох зэрэг ажлуудыг байнга зохиож,уралдааныг нилээд далайцтай өрнүүлсэн нь манай төв,орон нутгийн байгууллагуудын ажлын амжилтанд чухал нөлөө үзүүлсэн юм.

#### НЭГ.Хөдөө аж ахуйн талаар

Тус аймгийн засаг захиргаа, хөдөө аж ахуйн байгууллагууд мал аж ахуйг өсгөн хөгжүүлэх талаар авч явуулсан арга хэмжээндээ малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор үржлийн ажилд тодорхой чиглэл тогтоож, үхэр,бог малд зохиомол ба гар хээлтүүлгийн арга өргөн нэвтрүүлснээр үржил зохиомол хээлтүүлгийн станц 2-ыг шинээр байгуулж,бүх нэгдлийн 44 хувийг үржил зохиомол хээлтүүлгийн үйлчилгээнд хамарлаа. Ялангуяа үхэр сүргийн үржлийн ажлыг сайжруулах зорилгоор сүргийн доторхи хамгийн шилдэг хэсгээр бүрэлдсэн үхрийн үржлийн ферм 15—ыг шинээр байгуулж аймгийн бүх нэгдэл, сангийн аж ахуйнуудыг эдийн засгийн нөхцөл байдлаар нь 3 бүсээр үйлдвэрлэлийн чиглэлийг тогтоож өгөв. Малын төлийг дав шилттай шинэ аргаар бойжуулах ажлыг олонх нэгдэл, сангийн аж ахуйнуудад нэвтрүүлж 1963 онд бог малын төлийн 55 хувийг, 1964 онд 50,4 хувийг хөрвийн аргаар бойжуулснаар 1962 онд бойжуулсан төлийн хэмжээнээс 1963 онд 56 мянган төл,1964 онд 62 мянган төл илүү бойжуулж авлаа. 1963—1964 онуудад нийтдээ малын саравчтай хашаа 633-ыг барьж,өрөмдмөл худаг 15, уурхайн худаг 136-г тус тус гаргав. Аймгийн хэмжээгээр жил бүр 108—109 мянган тонн өвс тэжээл, тарианы хэдэн мянган тонн сүрэл,үр тарианы хаягдал бэлтгэдэг болсон нь зөвхөн үхэр,хонь,ямаанд элбэг хүрэлцэх тэжээлийн бат баазтай болсоны дээр зарим газар малын шинэ нэр төрлийн тэжээл санаачлан хийж байна. Борнуурын сангийн аж ахуй малын тэжээлд зориулж багсармал тэжээлийг үйлдвэрлэлийн аргаар хийх болсон бөгөөд одоо уг тэжээлд лабораторын шинжилгээ хийгдэж байна. Энэ нь нийт сангийн аж ахуйнууд, зарим нэгдлүүдэд дэлгэрүүлж болох үр дүнтэй зүйл юм.

Мал аж ахуйд шинжлэх ухааны ололт, тэргүүний туршлага нэвтрүүлэх талаар нилээд ажил хийгдэж БНМАУ—ын хөдөлмөрийн баатар Очирын туршлагаар отроор мал таргалуулах ажлыг аж ахуйн кампанит ажил болгон зохион байгуулалттай явуулах болсноос үлэмж амжилт олж байна. Зөвхөн энэ онд аймгийн хэмжээгээр 330 гаруй мянган мал отроор таргалуулж сайхан үр дүн олсны дотроос Алтанбулаг сум—нэгдлийн 30 гаруй мянган хонь нэг бүр дунджаар 14 кг, Эрдэнэ сум—нэгдлийн бүх хонь дунджаар 16 кг, ямаа 18,6 кг тарга хүч авсан байна. Нам, засгаас нэгдлийн гишүүдийн хүчийг нягтруулан хөдөлмөрийг хорших тухай шинэ журам тогтоосноор суурь хэсгийг байгуулах ажил явагдаж аймгийн хэмжээгээр 1317 суурь байгуулагдаж сангийн аж ахуй,нэгдэл,мал аж ахуйн машинт станцууд төрөл бүрийн мэргэжилтэй боловсон хүчнээр ихээхэн бэхжлээ.

Үржлийн мал худалдан авах,тэжээл бэлтгэх,хашаа саравч барих, үр тариа татах зэрэг үйлдвэрлэл явуулахад нь зориулж нэгдлүүдэд 1963—1964 онуудад нийтдээ 7,2 сая төгрөгийн урт богино хугацааны зээл олгов.

Эдгээр арга хэмжээнүүдийн үр дүнд мал сүргийн тоо толгойг өсгөж, ашиг шимийг дээшлүүлэх талаар ихээхэн амжилтанд хүрч өнгөрсөн 1963 онд аймгийн хэмжээгээр мал өсгөх улсын төлөвлөгөөг 103,3 хувиар биелүүлж,мал өсгөх төлөвлөгөөг 21 сум—нэгдэл, сангийн аж ахуй давуулсны дотор Баянцагаан, Батсүмбэр Өндөрширээт сумд аймагтаа тэргүүн 3 байр эзлэв. Малын тоо толгойг өсгөхийн хамт түүний товарлаг чанарыг өөрчлөн сайжруулах талаар ихээхэн ажил хийгдлээ. Аймгийн хэмжээгээр 1962 оноос 1964 онд цэвэр үүлдрийн ба эрлийз үхрийн тоо 59,1 хувь,хонь хоёр дахин нэмэгдлээ. Олонх сангийн аж ахуйнууд ихэвчлэн цэвэр ба сайжирсан үүлдрийн үхэр,хонь зонхилох боллоо Малын товарлаг чанарыг дээшлүүлэхийн тулд үржлийн ажлын нилээд арга хэмжээнүүд авагдаж энэ онд Баян, Баянзүрх зэрэг нэгдлүүдийн 55 мянган хонинд зоотехникийн чанарын ангилалт хийж анги чанараар нь суурилан үржлийн талаар цэгцэлсэн ба сүү, сүү—махны бүсийн 9 нэгдлийн үхэр сүрэгт ашиг шим,бие галбирын ангилалт хийж 1965-1970 оны үрж-

(Үргэлж лэл нь 2 дугаар нүүрт)

# Аймгийн АДХ—ын 6 дахь удаагийн 6 дугаар чуулганд Аймгийн АДХ—ын Гүйцэтгэх захиргааны ажлын тухай

## Аймгийн АДХ—ын Гүйцэтгэх захиргааны дарга, депутат Ц. Жамсрангийн тавьсан ИЛТГЭЛЭЭС

*(Үргэлжлэл)*

лийн хэтийн төлөвлөгөөг111 нэгдэл дээр хийж байна.

Нэгч малаас авах ноос,ноолуур,сүү, махны гарцыг нэмэгдүүлэх, хөдөлгөөн дээшилж байгаагийн үрээр улсад тушаах 5 төрлийн ноосны төлөвлөгөөг 1963 онд 49,7 тонноор, 1964 онд 21,9 тонноор тус тус давуулан биелүүлэв. Гэвч мал өсгөх түүний ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг манай олонх сум—сангийн аж ахуй нэгдлийн удирдах нөхөд мал аж ахуйн мэргэжилтэн нар гартаа байнга авч нарийн тооцоо судалгаатай жолоодон удирдаж чадахгүй байна.

Ерөнхий тооцоогүй удирдах явдал нь төрөл бүрийн малын хээлтүүлгийн ажлыг урсгалаар явуулах, хяналт шалгалтыг сулруулан төл ба том малын зүй бус хорогдлыг ихээр гарах боломж бий болгож улмаар мал өсгөх төлөвлөгөөг тасалдуулахад хүрэх ноцтой дутагдал болж байна. 1964 онд сум—сангийн аж ахуй, нэгдэл бүр мал өсгөх төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн тулд тооцоо сайн хийж боломцоо бүрийг нарийн ашиглах хэрэгтэй. Үржил зохиомол хээлтүүлгийн станцууд мал сүрэгт шилэлт сонголт хийх, үржлийн ажлын журам дараалал тогтоох, ашиг шим, амьдын жинд эрдэм шинжилгээний үндэстэй судалгаа хийх, үхэр хонины үржлийн фермийг шинжлэх ухааны үүднээс удирдах талаар ахиц гаргахгүй байна.

Энэ жил-үнээний хээлтүүлэг зарим сумдад урсгалаар явагдаж өнгөрсний дотор аймгийн хэмжээгээр үнээний зохиомол хээлтүүлгийн төлөвлөгөө 10 хувиар тасарч хээлтэгч насны бүх үнээний 13 хувийг зохиомолоор хээлтүүлсэн нь өнгөрсөн оныхоос 4 хувиар буурсан байна. Мал аж ахуйн ажиллагааны шийдвэрлэх нөхцөл болсон малыг тарган тавтай өвөлжүүлэх, тарга хүчийг тогтоох, бог малын төл хүлээн авах бэлтгэлийг ойрын хугацаанд бүрэн хангах явдал хамгийн чухал ээлжит зорилт болж байна. Өвлийн бэлтгэлийг муу хийвэл юунд хүрдэгийг өнгөрсөн өвлийн цаг зудын хүнд байдал тодорхой харуулсан билээ. Гэтэл энэ жил Дэлгэрхаан, Эрдэнэ зэрэг сумд хадлангийн төлөвлөгөөг тасалсаны дээр зарим сумд өвс тэжээлээ өвөлжөөндөө татаж аваагүй хашаа саравч худаг усаа засварлаж дулаалаагүй байна.

Өвс тэжээлийг сайн хадгалж,арвилан хэмнэх зөв зохистой зарцуулах явдал цагийн хатууд шийдвэрлэх ач холбогдолтой учир бэлт гэсэн өвсийг сайн хамгаалж мөнгөөр тооцоолж зарцуулж байвал зохино. 1964 онд аймгийн хэмжээгээр 1962 оноос даруй 11 мянган төл илүүгээр хорогдуулж Лүн,Заамар, Дэлгэрхаан зэрэг сумд 2000-4000 төл арчилгааны муугаас хорогдуулсан зэргээс аймгийн хэмжээгээр энэ жил 16700 төл төлөвлөгөөнөөс дутуу авчээ.

Энэ дутагдал 1965 онд давтагдах эсэх нь гагцхүү төлийн бэлтгэлийг хэрхэн хангаснаас шалтгаална. 1965 онд төл хүлээн авах бэлтгэл ажил бас л удаашралтай явагдаж байгаад дүгнэлт хийж суурийдын малын билчээрийг нөөцлөх,ус, хашаа, саравч дулаалах, тэжээл татах ажлыг шуурхай хийж 1965 онд хүлээн авч бойжуулах нутгийн монгол хонины төлийг хөрөвжилтийн үе шатаар саравчтай хашаанд 1 ба түүнээс дээш үеийн эрлийз төлийг эхлээр битүү дулаан байранд бойжуулах бүх бэлтгэлийг энэ 12 дугаар сард багтааж хийх хэрэгтэй. Мал өвлжилтийн дутуу зүйлийг суурь бүр дээр ойрын хугацаанд хангахад албан байгууллага, бүх хүн хүчийг дайчлан ажиллах нь чухал байна. Ялангуяа өсвөрийн ба саалийн малыг тэжээхийн ач холбогдлыг малчдад сурталчлан ойлгуулах,мал тэжээх аргад малчдыг сургах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авах нь зүйтэй. Хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэлийн салбарыг өргөтгөн тэдгээрийг нарийн тооцоотой удирдах, сангийн аж ахуй, нэгдлүүдэд ашигтай ажиллагааг аль болохоор нэвтрүүлэх, хөдөлмөр зохион байгуулалтыг цэгцлэх ажлыг 1965 онд бүрэн дуусгах хэрэгтэй.

Сангийн аж ахуй нэгдлийн 1964 оны мөнгөн орлогын төлөвлөгөөг биелүүлэх шуурхай арга хэмжээ авах, 1965 оныг сангийн аж ахуй нэгдлийн үйлдвэрлэлд бүртгэл тооцоо нэвтрүүлэх он болгон ажиллахаар зохих бэлтгэлийг одооноос хийвэл зохино.

Газар тариалангийн ажил тус аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд биеэ даасан салбар болон хөгжиж сайхан амжилтанд хүрч байна. Тариаг ангилан хураах үтрэм, үрлэгчийг механикжуулан газрыг салааны зохион байгуулалтаар эзэмшүүлэх, хөрсийг агрегадын аргаар боловсруулах үр суулгалтын дараа булдалт хийх, сүрлийг талбайгаас хураалттай зэрэгцүүлэн гаргах зэрэг дэвшилттэй арга ажиллагаанууд сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станцуудад нэвтэрч байна. Аймгийн хэмжээгээр 1964 онд нийтдээ 111 мянган га газар үр тариа хүнсний ногоо, төрөл бүрийн ургамал тариалсан нь 1962 оныхоос 21 хувиар нэмэгджээ. Үр тарианы ургац хураан авах улсын төлөвлөгөөг 1963 онд 105 хувиар, 1964 онд 112,5 хувиар тус тус биелүүлж 1965 онд хэрэглэгдэх нутагшсан үрийн нөөцтэй болж чаджээ,1964 онд үр тарианы төлөвлөгөөг Угтаал, Жаргалант, Баянцогт, Батсүмбэрийн сангийн аж ахуй, Лүн, Эрдэнэсант, Алтанбулаг, Сэргэлэн, Тариат сумын нэгдлүүд амжилттай биелүүлэв.

Гэтэл Архустын сангийн аж ахуй агротехникийн шаардлагыг муу биелүүлж байснаас ургац авах төлөвлөгөөг 70 шахам хувиар тасалдуулав. Нэгдлүүдэд газар тариалангийн талаар үйлчилж байгаа мал аж ахуйн машинт станцуудын үйлчилгээ хангалтгүй байна.

Жишээ нь; Баяндэлгэрийн мал аж ахуйн машинт станцын 1964 оны ажиллагаанд чийгтэй уринш ашиглахыг сонирхохгүй хөрсний боловсруулалтыг хариуцлагагүй явуулсан, үрлэлтийн хугацаа үрийн нормыг зөрчсөнөөс ургац ихээр алдаж нэгдлүүдийг хохируулах явдал гарав.

Сангийн аж ахуй нэгдлүүд хүнсний ногоог өргөтгөх талаар муу анхаарч байгаагаас малын тэжээл авах төлөвлөгөөг 55 хувиар тасалдуулсан нь цаашид анхаарч засвал зохих дутагдал мөн.

Энэ мэт дутагдлыг эцэс болгох, мал аж ахуйн машинт станцуудыг зохион байгуулалт мэргэжлийн талаар удирдах удирдлагыг эрс сайжруулах хэрэгтэй байна. Газар тариалангийн үйлдвэрлэлд юуны урьд хөрс боловсруулалтыг агротехникийн шаардлага ёсоор явуулах техник бүрийн хүч чадлыг бүрэн ашиглах талаар МАХН—ын Төв Хороо, БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх, техникийн нийт ажилчдын мэргэжил, сахилга бат, хүмүүжил, ажлын хариуцлагыг дээшлүүлэхийн хамт станцын ажилчдын аж байдлыг сайжруулах арга хэмжээ авах хэрэгтэй.

Зарим нэгдлүүдийн жил дараалан ургац алдаж байгаа шалтгааныг судлан цаашид авах арга хэмжээг боловсруулах нь чухал байна. Одоо сангийн аж ахуйнууд, станцуудад техник засварыг зохион байгуулалт сайтай бүтээмжтэй хийх, ба өвлийн улиралд техникийн ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх курс семинарыг зориуд зохиож явуулах хэрэгтэй.

### ХОЁР Үйлдвэр барилгын талаар

Манай үйлдвэр барилгын байгуулалгуудын материаллаг бааз нь өсч орчин үеийн техникээр тоноглогдсоор байгаагийн үр дүнд үйлдвэрүүдийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 1963 онд 6,6 сая төгрөгт хүрч 1962 оноос 14,1 хувиар нэмэгдэв.

Аймгийн үйлдвэрлэлийн хоршооллын байгууллагууд 1963 оны төлөвлөгөөг 115,5 хувиар биелүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг 11 хувиар дээшлүүлж өөрийн өртгийг 2,3 хувиар хямдруулж холбооны хэмжээгээр 189 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар үйлдвэрүүдийн хоорондын социалист уралдаанд түрүүлэн аймгийн намын хороо, АДХ—ын гүйцэтгэх захиргааны шилжин явах туг хүлээн авчээ. Аймгийн төвийн үйлдвэр хоршооллын артель өргөжиж шинэ байр тохөөрөмжөөр тоноглогдон үйлдвэрлэлийг явуулах өргөн боломжтой болов. Аймгийн хэвлэх үйлдвэр 3 дугаар таван жилийн төлөвлөгөөг нэр төрлөөр нь 3 жил 11 сарын дотор биелүүлж сайхан амжилт гаргалаа.

Төвийн цахилгаан станц 1962 онд 950100 киловат цагийн энергийг гаргаж байсан бол 1963 онд 1 сая 345 мянган киловат цагийн энергийг үйлдвэрлэн гаргадаг болтлоо өргөжлөө.

Гэвч ихэнх үйлдвэрийн газруудын төлөвлөгөөний биелэлтийг үнийн дүнгээр хангахад голлон анхаарч бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан яс чанарыг сайжруулж ард олныхоо эрэлт хэрэгцээг хангахад төдийлөн анхаарч ажиллахгүй байна.

Ялангуяа хүнсний комбинат үйлдэхүүний нэр төрлийг олшруулах талаар ямарч санаачлага тавиагүйгээс варина, чихэртэй хуруудхийх төлөвлөгөөг 2 жил дараалан тасалдуулав.

Цөцгийн тос бэлтгэх энэ оны төлөвлөгөөг Баянбараат, Эрдэнэсант сумд тасалсаны уршгаар аймгийн хэмжээгээр тосны төлөвлөгөө 5,9 хувиар тасарч байна.

Түүнчлэн аймгийн үйлдвэрүүдээс гаргаж байгаа талх нарийн боовны амт чанар муугаас удаан хугацаагаар дарагдан хадгалагдахад хүрч байгаагийндээр үйлдвэрлэлийн холбооны гаргаж байгаа бүтээгдэхүүний хийц үзэмж туйлын муу байна.

Үйлдвэрийн газрууд ард түмний өдөр дутмын хэрэгцээг судлаж түүнд үйлдвэрлэлээ захируулахыг эрмэлздэггүйгээс гоймон, пүнтүүз, амтат ус,гэр аж ахуйн модон ба төмөр эдлэл, эсгий гутал хүүхдийн хувцас зэрэг зүйлүүдээр хүмүүс дутагдаж байна.

Манай нийт үйлдвэрүүд хөдөлмөрийг хөнгөвчлөх, үйлдвэрийн технологийг сайжруулан механикжуулах санаачлага туршлагуудыг огт өрнүүлэхгүй байна.

МАХН—ын Төв Хорооны 5 дугаар бүгд хурал барилгын ажлыг бүх ард түмний хэрэг болгон дэвшүүлсэн явдал, зөвхөн барилгачдаар барахгүй бүх үйлдвэр, албан газруудын эх оронч хөдөлгөөнийг өрнүүлсэн юм.

Материал, үзэл санааны энэ их дэмжлэгийн үр дүнд манай төв хөдөөд барилга байгуулалтын ажилд анхны амжилтууд гарч 1963—1964 онуудад зөвхөн аймгийн төвд биеийн тамирын танхим, цэнгэлдэх хүрээлэн, хүүхдийн цэцэрлэг, зочид буудал, орон сууц, сурагчдын ба үйлдвэрийн байр зэрэг 15 барилга хөрөнгө оруулалт ба аж ахуйн аргаар баригдаж ашиглалтанд орсон нь манай аймгийн хөдөлмөрчдийн үйл амьдралд бий болсон ололт юм.

Барилгын ажлын эрч хүчийг сайжруулах, барилгын үйлдвэрлэлийг бэхжүүлэх талаар аймгийн АДХ—ын гүйцэтгэх захиргаа нилээд арга хэмжээг авсан боловч тус аймгийн барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн ажил МАХН—ын Төв Хорооны бүгд хурлын заалтын хэмжээнд хүртэл сайжирч чадаагүй байна.

Аймгийн барилга контор ажилчдыг тогтворжуулах, тэдний мэргэжил чадварыг дээшлүүлэх, барилга байгуулалтын хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах талаар туйлын хангалтгүй ажиллаж иржээ. Зөвхөн 1964 онд барилгад саналаа өгч намынхаа дуудлагаар очсон 41 хүний 26 нь, элсэлтээр очсон 98 ажилчны 68 нь ажлаасаа гарчээ. Барилгын ажилд тоо бүртгэл тайлан тооцоо муу, материал хөрөнгийг үрэгдүүлэх, орон тоо төсвийг дур зоргоороо хэтрүүлэх явдал олонтой гарч байсны дээр орон нутагт ялангуяа нэгдлүүдэд

*Үргэлжлэл нь 3 дугаар нүүрт*

## Аймгийн АДХ—ын 6 дахь удаагийн 6 дугаар чуулганд Аймгийн АДХ—ын гүйцэтгэх захиргааны ажлын тухай

Аймгийн АДХ—ын гүйцэтгэх захиргааны дарга, депутат Ц. Жамсрангийн тавьсан ИЛТГЭЛЭЭС

*(үргэлжлэл)*

барилга барих ажил туйлын хангалтгүй байгаагаас олонхи нэгдлүүд үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөнд төлөвлөгдсөн барилга барихгүй тасалдаг байна.

Цаашид барилга конторын ажил дээр оршиж байгаа дутагдлыг арилгах, төлөвлөгөөт барилгуудыг барихад тэдний анхаарлыг бүрэн чиглүүлэх, сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдлүүд ба фермийн төвүүдэд хүртэл барилгын байнгын групп, бригадуудыг байгуулан ажиллах нь зүйтэй юм.

Аймгийн барилга конторт ирэх жил аймгийн нэгдсэн больниц, 36 айлын сууц зэрэг барагцаалбал 4,9 сая төгрөгийн барилга барих бөгөөд энэ үүргийг хугацаанд нь биелүүлэхийн тулд өвлийн улиралд барилгын материалын 60—аас доошгүй хувийг урьдчилан бэлтгэж ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх курс сургуулийг байгуулж ажиллах нь шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд нэгдэл сангийн аж ахуйнууд өөрсдийн төвүүд ялангуяа ферм бригадуудын төвийг тохижуулах талаар шийдвэртэй ажлуудыг зохион байгуулах хэрэгтэй.

### ГУРАВ. Тээвэр холбоо, бэлтгэлийн явцын талаар

Аймгийн 13 дугаар авто баазын машины тоо нэмэгдэн тоног төхөөрөмж нь сайжирч 1963 онд хүн, ачаа тээвэрлэх төлөвлөгөөг 100,5—107,1 хувь, орлогын төлөвлөгөөг 104,5 хувиар биелүүлсэний дээр чиргүүл ашиглах явдал мэдэгдэхүйц сайжирсан байна.

Аймгийн харилцаа холбооны байгууллага төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүлж аймгийн төв хот хоорондын харилцаанд зориулан шинэ аппарат 6, суманд харилцааны радио станц, Мөнгөнморьт суманд утсан харилцаа тавьснаар одоо Гачууртаас бусад бүх суманд утсан ба радио холбоотой боллоо.

Аймгийн хэмжээгээр бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлэхдээ график хугацааг зөрчих, нэр төрлийг тасалдуулах чанаргүй зүйлээр ор нэр болгохыг оролдох зэрэг оролдлого оршсоор байгаагийн дээр нэгдэл, худалдаа бэлтгэлийн ангиудын хоорондох аж ахуйн гэрээний биелэлт, хариуцлага ихээхэн сул явагдаж байна.

Үхсэн малын арьс, яс, тос зэрэг хаягдал муу ашгилдгаас малын яс бэлтгэх зэрэг чухал төлөвлөгөөт үүргүүд биелэгдэхгүй хохирох явдал олонтой гарч байна

Авто тээврийн баазын ажиллагаанд техникийн засвар үйлчилгээ муу техникийн хүчин чадлын ашиглалт хангалттай биш социалист уралдааныг зохиох, дүгнэх ажил сул, бинзен тос запас сэлбэгийг арвилан хэмнэж улс нийгмийн өмч хөрөнгөнд аж ахуйчаар хандах арга ажиллагаа бүрэн нэвтэрч чадаагүй байна.

Машин техникийн хүч чадлыг дээд хэмжээгээр ашиглах, техникийн мэргэжилтнүүдийн чадвар чансааг шалгах үндэс нь болсон 100 мянгатын хөдөлгөөнийг өрнүүлэх ажил зохиодоггүйгээс 100 мянгатнууд төрж гарахгүй байна.

Аймгийн харилцаа холбоо, холбооны орчин үеийн техникээр сайтар тоноглогдсон боловч нийтэд үйлчлэх үйлчилгээ хөнгөн шуурхай биш байна.

Харилцаа холбоо, тээврийн байгууллагын ажилчдын мэргэжил сахилга бат дорой явдал тэдний хамгийн гол дутагдал мөн.

Цаашид улсын бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлэхэд мал нэг бүрээс ашиглах ноосны гарцыг нэмэгдүүлж энэ талаар тэргүүний сайчуудын туршлагыг нийтийн хүртээл болгох үндсэн дээр бэлтгэлийн зүйлийг нэр төрөл нэг бүр дээр нь цаг тухайд нь биелүүлж байхыг хатуу зарчим болгох хэрэгтэй.

Төлөвлөгөөт үзүүлэлгийг биелүүлэхийн хамт машины хоосон гүйлт сул зогсолтыг багасгаж, даацыг дүүрэн ашиглах, ялангуяа чиргүүлийг дээд хэмжээгээр хэрэглэх, шатахуун сэлбэг хэрэгслэлийг арвилан хэмнэх, 100 мянгатын хөдөлгөөн, социалист уралдааныг өрнүүлэх явдал тээврийн байгууллагын өмнө хурцаар шаардагдаж байна. Аймгийн харилцаа холбоо 1965 онд Гачуурт, Бугын сангийн аж ахуйнууд ба хэд хэдэн бригадыг утсан харилцаатай болгож төв хөдөөгийн бүх өрхийг бүрэн радиожуулах ажлыг зохиох хэрэгтэй.

### ДӨРӨВ. Ард түмний аж байдал соёлын хэмжээний дээшлэлт.

Аймгийн АДХ—ын гүйцэтгэх захиргаа худалдаа үйлчилгээ соёл гэгээрэл эрүүлийг хамгаалах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласны дүнд хүн ардын материаллаг амьдралын хэрэгцээнд худалдаагаар, оюун санааны баялагийг арвижуулахад соёл урлагаар үйлчлэх үйлчилгээ өсөн нэмэгдэж ирлээ.

Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 1962 оныхоос 40 хувиар нэмэгдэж, энэ хичээлийн жилд 7400 хүүхэд суралцаж байна. Одоо тус аймагт 8 жилийн сургууль 5, 10 жилийн дунд сургууль 2, 7 жилийн дунд сургууль 6, бага сургууль 17 ажиллан сургалтын шинэ программар хичээллэж байна.

Насанд хүрэгчдийн оройн дунд сургуульд 330 хүн суралцаж байна. 1963—64 онуудад 9 цэцэрлэгийг шинээр байгуулж одоо 1000 хүүхэд бүхий 21 цэцэрлэг ажиллах боллоо.

Тус аймагт хүний их эмчийн салбар 13, сум дундын больниц нэг, бага эмчийн салбар 36, эмийн сан 14, хүүхдийн ясли 9, аймгийн төвд нарийн мэргэжлийн 10 гаруй их эмчтэй нэгдсэн больниц, 40 ортой хүүхдийн больниц болон арьс өнгө, сурьеэгийн диспансер, айргийн эмнэлэг, ариун цэврийн станц зэрэг урьдчилан сэргийлэх эмчлэн сувилах байгууллагууд ажиллаж байна.

1962 онд нэг их эмчид 1678 хүн ноогдож байсан бол одоо 1450 хүн ноогддог болж ард түмний эрүүл мэндийн байдал үлэмж дээшилж байна.

Хөдөлмөрчдийн ахуй амьдрал улам дээшлэж бодит орлого нэмэгдсээр байна.

Аймгийн хэмжээгээр 1963 онд нэгдлийн нэг гишүүн хөдөлмөрийнхөө хөлсөнд 1255 төгрөг авч байсан нь 1964 онд 1626 төгрөг болж нэмэгдлээ. 1963—64 онд зарцуулсан нийгэм соёлын арга хэмжээний зардал 1962 оныхоос 1,5-25,8 хувиар өссөн бөгөөд аймгийн улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх арга хэмжээний нийт төсөв 1964 онд 13,1 хувиар өссөн байна.

Худалдааны салбар цэгүүдэд барааны нөөц хэрэгцээг сайжруулахын тулд барааг татан авах, хуваарлих борлуулах ажлыг шуурхай зохион байгуулаагүй бараг хүн бүрт хүрэлцэхээр худалдахын тулд 1 хүнд худалдаалах барааны жагсаалтыг хатуу баримталдаггүй зэргээс зарим газруудад өргөн хэрэгцээний бараагаар тасалдах явдал ч гардаг байна. Худалдааны олонхи байгууллагуудын дэлгүүр, нийтийн хоолны газруудын үйлчилгээ боловсон бус, ариун цэвэрч байдал нэвтрээгүй хоолны амт чанар муу байгаагийн дээр загас, шувуу, туулайн мах, цагаан идээ, ногоо, жимс зэргийг хоолонд хэрэглэхгүй малын мах л байхгүй бол нийтийн хоолны газруудыг хаахад хүрдэг байна.

Худалдаа бэлтгэлийн орон нутгийн зарим байгууллагуудын нэг гол дутагдал бол бэлтгэлийн төлөвлөгөөг голчлоод ард түмэнд үйлчлэх тэдний төлөө санаа тавих асуудалд сул анхаарч байгаа явдал мөн. Лүн сумын төвд одоо хүртэл цахилгаан гэрэл халуун ус, үсчин талх барих газар байхгүй байгаагийн дээр нийтийн хоолны газрууд нь зорчин явагчид болон төвийнхнийгөө үргэлж гачигдуулж, элдэв шалтгаанаар хаалттай байх нь олонтой болжээ.

Сумдын төвүүдэд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний газруудыг байгуулж байнгын үйлчилгээтэй байлгах талаар аймгийн намын хороо АДХ—ын гүйцэтгэх захиргааны удаа дараагийн шийдвэрүүд төдийлөн биелэгдэхгүй байна. Хөдөө аж ахуйн нэгдлийн бригадуудыг төвлөрүүлж тэнд соёл үйлчилгээний барилга барих ажил нэн хоцрогдонгүй байна.

Аймгийн цахилгаан станц төвийн хөдөлмөрчдийг цахилгаан гэрлээр маш хангалтгүй үйлчилж байна. Олонхи ажилчдын сахилга бат, ажлын хариуцлага сул, шугам сүлжээний буруу зэргээс цахилгаан гэрэл асаж унтрах, улайх зэргээр хүмүүсийн хэрэгцээг хангаж чадахгүй байна. Төв хөдөөд радио телефон харилцуурын сонсгол муу бичиг шуудан хэвлэл тараалт удаан харилцаа холбооны ажилчдаас олон түмэнд түргэн шуурхай үйлчлэхгүй байна.

МАХН—ын Төв Хорооны захидал, сургалтын шинэ системийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар ардын гэгээрлийн ба засаг захиргааны байгууллагууд хангалтгүй ажиллаж байгаагаас сурагчдын сурлага хүмүүжил ялангуяа сургалтыг үйлдвэрлэлтэй холбох ажилд багагүй дутагдал оршиж байна.

1963—64 оны хичээлийн жилийн эцэст аймгийн хэмжээгээр 320 хүүхэд буюу бүх сурагчдын 4,9 хувь нь анги улирчээ.

Лүн, Өнжүүл Батсүмбэр сумдын сургуулийн ариун цэвэр, аж ахуйн тохижилт хангалтгүй түлээ түлшээр тасалдах явдал гарсаар байна. Соёл үйлчилгээний ажилд сум хороодын АДХ—ын гүйцэтгэх захиргаа хяналт шалгалт тавьж оновчтой удирдлага өгөх талаар биетэй ажил зохиохгүй байна.

Түүнчлэн дэргэдээ байгаа сургууль, соёл гэгээрэл, эмнэлэгийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэхэд зарим сангийн аж ахуй, нэгдлүүд тэдэнд орон байр түлээ түлш хүнс тэжээл, аж ахуйн төхөөрөмжөөр туслаж дэмжихгүй гачигдуулдаг байна.

Өөрийнхөө хөрөнгөөр сурагчдын дотуур байр, сууц барьж байгаа зарим, сангийн аж ахуй, нэгдлүүдийн үлгэр жишээч ажиллагааг нийт сангийн аж ахуй, нэгдлүүдэд хэрэгжүүлэхгүй байгаагаас олон тооны эцэг эх хүүхдээ дагаж сумын төвд сууж нэгдлийн үйлдвэрлэлээс хөндийрсөн хэвээрээ байна. Түүнчлэн эхчүүдийг төрхийн өмнө ба хойно амрах байрыг Тариат, Баяндэлгэр, Бүрэн зэрэг сум нэгдлүүд одоо хүртэл байгуулаагүй ба зарим байгуулсан газар ч уг байраа тохижуулж тогтмол ажиллуулахгүй нам засгийн заалтыг зөрчиж олон зуун эхчүүдийг хохируулж байгаа явдалд сүрхий анхаарах цаг болсон байна.

Тус аймагт биеийн тамир спортын ажил нийт ард түмний хэрэг болж чадаагүй байгаагаар үл барам энэ нь хамгийн хоцрогдсон ажлын нэг болж байгаа явдалд дүгнэлт хийж ойрын хугацаанд ажлаа эрс өөрчлөн сайжруулах явдал биеийн тамирын нийгэмлэгийн өмнө хурцаар шаардагдаж байгаа бөгөөд ялангуяа өвөл цагийн спортын ажилд хөдөлмөрчдийг өргөнөөр татан оролцуулж эхлэх хэрэгтэй.

Манай эх оронд социализмыг бүтээн байгуулалтанд асар их хөрөнгө материал шаардагдаж байгааг анхаарч улсын төсвийн зарцуулалтыг төсвийн нормоос хэтрүүлэх өөр зүйлд зарцуулах явдлыг бүрмөсөн зогсоож төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг хүчтэй болгохын дээр орлого хуримтлалын эх үүсвэрийг нээн илрүүлж төлөвлөгөөг жигд биелүүлэх талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч ажиллах явдал манай үйлдвэр, аж ахуйн байгууллага сум, хороодын өмнө тавигдаж байгаа чухал зорилт болж байна.

НӨХӨД ӨӨ!

Тайлангийн хугацаанд аймгийн АДХ—ын гүйцэтгэх захиргааны

*(Төгсгөл нь 4 дүгээр нүүрт)*